

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТ

Дарив сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/020/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Цэрэнханд Утас: 99086371 Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn Аудитор: С.Санчирмаа Утас: 99282488 Цахим хаяг: sanchirmaas@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГАА-2025/020/НА-СТА-ТТЗ



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099  
Утас: (976) 70 48 34 13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025. 03. 24 № 122

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дарив сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доор зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.7, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2.5, 41.2.7 дахь заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөө 110,315.5 мянган төгрөгөөр тасарсан, Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг дутуу бүрдүүлсэн,
- Улсын тэмдэгтийн хураамжийн орлого 510.4 мянган төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 593.6 мянган төгрөгөөр, газрын төлбөрийн орлого 4,228.7 мянган төгрөгөөр, торгуулийн орлого 517.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан,

8225020348

- Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн харьяа нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 528,473.7 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

#### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд зохион байгуулсан сумын 100 жилийн ойн арга хэмжээний зардалд аймгийн төсвөөс санхүүжилт олгоогүй байна.

Засгийн газрын 2024 оны 231 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалин нэмсэн, мөн оны 83 дугаар тогтоолоор Төрийн захиргааны албан хаагчид 5 жил тутамд 6 сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн урамшууллыг олгожээ.

“Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолоор нийт 4 орон тоо нэмэгдсэн байна.

Сумын Орон нутгийн төсвийн орлогыг 466,966.5 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 407,477.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 59,488.6 мянган төгрөгөөр буюу 87.3 хувьтай биелүүлсэн байна.

Тайлант онд аймгийн төсвөөс 967,087.1 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 150,418.0 мянган төгрөгийг дутуу санхүүжүүлсэн байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

Сумын орон нутгийн төсвөөс Засаг даргын Тамгын газарт 40,408.3 мянган төгрөгийн, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 7,367.1 мянган төгрөг, Ерөнхий боловсролын сургуульд 30,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна.

Орон нутгийн хөгжлийн сан, сумын ойн хандив болон бусад эх үүсвэрээс 54,385.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд 27 зорилт 85 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 85.7 хувьтай үнэлсэн байна.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Г.ГҮНЖИДМАА



**Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан (мянган төгрөг)**

**2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон**

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	671,399.2	842,187.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	171,587.7	274,144.0
33	АВЛАГА	212,083.0	173,426.2
35	БАРАА МАТЕРИАЛ	251,083.6	317,928.6
36	НӨӨЦИЙН БАРАА	36,645.0	36,645.0
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	-	40,044.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,443,850.6	1,779,737.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,443,850.6	1,779,737.9
39200	Биет хөрөнгө	1,210,299.8	1,558,415.1
39300	Биет бус хөрөнгө	233,550.8	221,322.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,115,249.8	2,621,925.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	107,601.0	200,374.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	107,601.0	200,374.8
41300	Өглөг	107,601.0	200,374.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,007,648.8	2,421,550.8
51	Засгийн газрын хувь оролцоо	2,007,648.8	2,421,550.8
51100	Засгийн газрын оруулсан капитал	621,119.0	608,891.0
51200	Хуримтлагдсан үр дүн	1,175,642.7	1,601,772.7
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	210,887.2	210,887.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,115,249.8	2,621,925.6

**2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан (мянган төгрөг)**

**2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон**

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,484,686.9	1,956,033.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	307,723.6	401,460.0
110	Орлогын албан татвар	213,700.3	342,133.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	222,594.5	359,173.3
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(8,894.2)	(17,039.6)
113	Хөрөнгийн албан татвар	88,411.9	53,615.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	5,611.4	5,710.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	305,830.8	539,016.4
120	Нийтлэг татварын бус орлого	305,830.8	539,016.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,871,132.6	1,015,556.6
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,048,355.8	1,379,104.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,048,355.8	1,379,104.6

Дарив сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,063,350.2	1,259,470.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	405,954.6	535,652.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,777.5	77,473.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	345,831.5	385,054.3
2104	Хангамж, бараа материалын зардал	29,223.3	24,926.3
2105	Норматив зардал	95.0	165.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,609.4	10,241.8
2107	Томилолт, зочны зардал	5,176.0	6,236.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51,320.3	41,627.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	152,362.5	178,093.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	985,005.6	119,634.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	436,331.1	576,928.3
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	216,567.6	145,673.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	219,763.6	431,254.9

**2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөг)**

**2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон**

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,775,657.3	-	1,775,657.3
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,775,657.3	-	1,775,657.3
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	12,228.0	-	12,228.0
Зарласан ногдол ашиг	-	-	-
Тайлант үеийн үр дүн	219,763.6	-	219,763.6
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,007,648.8	-	2,007,648.8
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,007,648.8	-	2,007,648.8
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(17,352.9)	-	(17,352.9)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,990,295.9	-	1,990,295.9
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-

Тайлант үеийн үр дүн	431,254.9	-	431,254.9
2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,421,550.8	-	2,421,550.8

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөг)

### 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,230,726.4	1,512,947.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	307,723.6	401,460.0
110	Орлогын албан татвар	213,999.1	342,133.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	222,893.3	359,173.3
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(8,894.2)	(17,039.6)
113	Хөрөнгийн албан татвар	88,113.1	53,615.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	5,611.4	5,710.4
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,981.8	2,146.0
1181	Газрын төлбөр	3,629.6	3,564.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	43,845.4	95,931.2
120	Нийтлэг татварын бус орлого	43,845.4	95,931.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,879,157.4	1,015,556.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,956,664.7	1,176,855.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,956,664.7	1,176,855.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	964,634.3	1,057,220.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	405,438.5	541,110.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,777.5	70,417.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,440.0	347,050.1
2104	Хангамж, бараа материалын зардал	25,790.4	21,673.8
2105	Нормативт зардал	95.0	429.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,197.2	10,241.8
2107	Томилолт, зочны зардал	5,176.0	6,236.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	382,542.1	32,246.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	66,177.5	27,816.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	992,030.4	119,634.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	274,061.7	336,092.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	288,387.1	233,536.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	288,387.1	233,536.0
2200	Дотоод эх үүсвэрээр	288,387.1	233,536.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(288,387.1)	(233,536.0)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(85,000.0)	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	85,000.0	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(99,325.3)	102,556.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	270,913.0	171,587.7

20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	171,587.7	274,144.0
----	---	-----------	-----------

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

### 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,653,190.1	1,386,535.2	266,654.9	83.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,282,514.8	1,200,817.8	81,697.0	93.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,160,434.3	1,081,183.2	79,251.1	93.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	561,641.5	541,110.1	20,531.4	96.3
210101	Үндсэн цалин	278,692.3	321,951.0	(43,258.7)	115.5
210102	Нэмэгдэл	245,949.2	213,038.1	32,911.1	86.6
210104	Урамшуулал	33,800.0	6,055.6	27,744.4	17.9
210105	Гэрээт ажлын хөлс	3,200.0	65.4	3,134.6	2.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,417.0	70,417.0	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	50,591.3	49,750.3	841.0	98.3
210202	Тэтгэмжийн даатгал	5,186.6	5,186.6	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,903.8	3,903.8	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	975.9	2,034.0	(1,058.1)	208.4
210205	Эрүүл мэндийн даатгал	9,759.4	9,542.3	217.1	97.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	378,995.7	347,050.1	31,945.6	91.6
210301	Гэрэл, цахилгаан	15,290.0	13,438.2	1,851.8	87.9
210302	Түлш, халаалт	362,895.7	333,101.9	29,793.8	91.8
210303	Цэвэр, бохир ус	810.0	510.0	300.0	63.0
2104	Хангамж, бараа материалын зардал	32,708.2	21,673.8	11,034.4	66.3
210401	Бичиг хэрэг	2,950.0	2,780.6	169.5	94.3
210402	Тээвэр, шатахуун	24,200.0	14,606.5	9,593.5	60.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,000.0	3,000.0	-	100.0
210404	Ном, хэвлэл	540.0	-	540.0	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	622.1	622.1	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,396.1	664.7	731.4	47.6
2105	Норматив зардал	600.0	429.8	170.2	71.6
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600.0	429.8	170.2	71.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,624.0	50,241.9	382.2	99.2
210602	Тавилга	20,000.0	20,000.0	-	100.0
210604	Урсгал засвар	30,624.0	30,241.9	382.2	98.8
2107	Томилолт, зочны зардал	8,200.0	6,236.0	1,964.0	76.0
210702	Дотоод албан томилолт	8,200.0	6,236.0	1,964.0	76.0

Дарив сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,672.5	15,888.4	3,784.1	80.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,692.5	12,282.0	1,410.5	89.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	900.0	604.8	295.2	67.2
210803	Даатгалын үйлчилгээ	500.0	500.0	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300.0	-	300.0	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	200.0	121.0	79.0	60.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,080.0	1,794.4	285.6	86.3
210807	Газрын төлбөр	2,000.0	586.2	1,413.8	29.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,575.4	28,136.1	9,439.4	74.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,575.4	25,904.1	6,671.4	79.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000.0	2,232.0	2,768.0	44.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	122,080.5	119,634.6	2,445.9	98.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	122,080.5	119,634.6	2,445.9	98.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	40,284.0	40,284.0	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	79,291.5	79,291.5	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,505.0	59.1	2,445.9	2.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	350,675.3	185,717.4	164,957.9	53.0
223001	Бусад хөрөнгө	350,675.3	185,717.4	164,957.9	53.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	20,000.0	-	20,000.0	-
230001	Эргэж төлөгдөх зээл	20,000.0	-	20,000.0	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,653,190.1	1,476,678.5	176,511.6	89.3
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,608,373.3	1,406,730.3	201,643.0	87.5
320001	Орон нутгийн төсвөөс	1,439,225.3	1,245,024.8	194,200.5	86.5
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	169,148.0	161,705.5	7,442.5	95.6
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	44,816.8	69,948.2	(25,131.4)	156.1
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	69,891.4	(69,891.4)	
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	800.0	56.8	743.2	7.1
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	44,016.8	-	44,016.8	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	98,736.4	(98,736.4)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	188,879.6	(188,879.6)	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

ГАА-2025/020/НА-СТА-ТТЗ

**2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон**

Дансны код	Үзүүлэлт	Мөнгөн дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	44,206.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	44,206.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	23,856.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,357.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,357.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,498.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,498.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,350.5
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,350.5
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	20,350.5
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	44,206.9
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	44,206.9
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	800.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,987.4
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,419.4
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

Залруулагдаагүй нийт 193.9 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшин их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 193.9 сая төгрөгийн 3 зөрчил илрүүлснээс, зөрчлийг давтан гаргахгүй байх 3 албан шаардлага хүргүүлсэн.

**3.1.1 Харьяа байгууллагууд**

Дарив сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 1 Дарив эрчим хүч аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, 3 тусгай сан, 4 байгууллагын (Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв) тогтмол зардал нэгтгэсэн байна.

Аудитаар ЗДТГ-ын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн ба сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн сан, Орон нутгийн хөгжлийн сан, Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлыг аудитын түүвэрт хамруулсан.

**3.1.2 Түүвэрт хамрагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил**

Аудитаар санхүүгийн тайлангийн бүртгэл, тайлагналыг 208.4 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 10 алдааг залруулж, 1.4 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 299.8 сая төгрөгийн 6 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн байна.

### **3.1.3 Аудитаар Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил**

Аудитаар бүртгэл тайлагналтай холбоотой 45.0 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 2 алдааг залруулж, 213.4 сая төгрөгийн 5 зөрчил илрүүлж, 0.9 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 212.4 сая төгрөгийн зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 4 албан шаардлага хүргүүлсэн байна.

### **3.2 Төсвийн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 193.9 сая төгрөгийн 3 зөрчил илрүүлснээс 116.2 сая төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага, 77.8 сая төгрөгийн 1 заалт зөвлөмжийг хүргүүлж байна.

### **3.3 Албан шаардлага**

1. Орон нутгийн орлогыг төлөвлөснөөс малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөө 110.3 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 0.5 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж 0.6 сая төгрөгөөр, газрын төлбөрийн орлого 4.2 сая төгрөгөөр, торгуулийн орлого 0.5 сая төгрөгөөр тус тус тасарсан нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 41 дүгээр зүйлийн 41.1-т "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.5-т "энэ хуулийн 37.1.8-д заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх;" Дарив сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 23 дугаар тогтоолыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангуулж ажиллан, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 723.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс аудитын явцад 208.4 сая төгрөгийн алдааг залруулж, 2.4 сая төгрөгийн төлбөрийн акт, 512.2 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих"; гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

### **3.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт:

ГАА-2025/020/НА-СТА-ТТЗ

Орон нутгийн төсвөөс 50.4 сая төгрөгийг дутуу санхүүжүүлсэн. Сумын орон нутгийн төсвөөс Засаг даргын Тамгын газарт 40.4 сая төгрөгийн, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 7.4 сая төгрөг, Ерөнхий боловсролын сургуульд 30.0 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.16-т "төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн байгууллага, бусад этгээдэд улсын төсвөөс санхүүжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг батлагдсан төсвийн дагуу олгох; 41 дүгээр зүйлийн 41.2.5-т "энэ хуулийн 37.1.8-д заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх;" Дарив Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 23 дугаар тогтоолтой нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийн хуваарийн дагуу нэгж байгууллагуудад санхүүжилтийг олгож байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу илэрхийлсэн тусган		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дарив сумын Засаг даргын нэгтгэсэн тайлан	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дарив сумын Засаг даргын Тамгын газар	2	44,995.6	-	-	2	44,995.6	2	44,995.6	-	-	-	-
Дарив сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	3	8,986.6	-	-	3	8,986.6	3	8,986.6	-	-	-	-
Дарив сумын Орон нутгийн хөгжлийн сан	3	132,043.5	-	-	3	132,043.5	3	132,043.5	-	-	-	-
Дарив сумын Хоршоо хөгжүүлэх сан	2	22,432.2	-	-	2	22,432.2	2	22,432.2	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>10</b>	<b>208,457.9</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>10</b>	<b>208,457.9</b>	<b>10</b>	<b>208,457.9</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

##### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Байгууллагын нэр	Бүгд	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзах түүвэрт	Нийт зөрчил		Үүнээс									
						Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
								Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Дарив сумын Засаг даргын нэгтгэсэн тайлан	1	-	1	-	-	3	193,940.6	-	-	2	116,165.2	1	77,775.4	-	-	-	-

Дарив сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дарив сумын Засаг даргын Тамгын газар	1	-	1	-	-	-	5	213,412.3	1	973.5	4	212,438.8	-	-	-	-	-	-
Дарив сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1	-	-	-	-	1	2	1,906.0	-	-	2	1,906.0	-	-	-	-	-	-
Дарив сумын Орон нутгийн хөгжлийн сан	1	-	-	-	-	1	4	297,867.0	-	-	4	297,867.0	-	-	-	-	-	-
Дарив сумын Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан	1	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дарив сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	-	-	-	-	1	1	1,414.4	1	1,414.4	-	-	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>4</b>	<b>15</b>	<b>708,540.3</b>	<b>2</b>	<b>2,387.9</b>	<b>12</b>	<b>628,377.0</b>	<b>1</b>	<b>77,775.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөг)

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дарив сумын Засаг даргын Тамгын газар	1	-	-	-	-	-	1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТТЗ	1	1				1		
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		